



**МОНГОЛЫН ГАЗАР ЗҮЙН
ОЛИМПИАДЫН ХОРОО ХОЛБОО НҮТББ**

14201, Улаанбаатар хот – 46а/484

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, МУИС-ийн 2 дугаар байр, 240 тоот

2025.11.19 № 20.
танай _____-ны № _____-т

Газарзүйн олимпиадын хоёрын даваанд асуулт даалгавар хүлээн авах тухай

Энэ хичээлийн жилийн газарзүйн олимпиадын хоёрын даваа 2025 оны 12 сарын 16-нд орон даяар зохион байгуулагдах гэж буйтай холбогдуулан даалгавар хүлээн авна. Хавсралт дахь удирдамжтай танилцан, хамтран ажиллахыг урьж байна.

ДАРГА



В. БАТЦЭНГЭЛ

2025-2026 оны хичээлийн жилийн газарзүйн олимпиадын хоёрын даваанд даалгавар хүлээн авах удирдамж



Даалгаврууд нь задгай болон тест хэлбэртэй байна. Нийт 150 тест, 15 задгай даалгавар хүлээн авах боломжтой.

Тест нь аливаа дүрслэлийн хэлбэр ашигласан, 4 хүртэлх хариултын хувилбартай, зөвхөн нэг зөв хариутай байна. Тестийг нэг хэлбэрээр бэлдэх ба зөв хариултыг улаан өнгөөр тодруулна. Агуулгын хувьд газарзүйч сэтгэлгээ, орон зайн сэтгэлгээ, сурах бичгийн хүрээнд багтсан байна.

Задгай даалгавар нь

- Дэлхийн бүтэц, бүрэлдэхүүн, чулуулаг
- Гадаргыг өөрчлөгч хүчин зүйлс, түүний үр дагавар
- Уур амьсгал ба уур амьсгалын өөрчлөлт
- Ландшафт, газар ашиглалт
- Байгалийн гамшигт үзэгдэл, гамшгийн менежмент
- Хүн ам, түүний өөрчлөлт
- Эдийн засгийн газарзүй ба глобальчлал
- Хөгжлийн газарзүй, орон зайн тэгш бус байдал
- Хотын газарзүй, хот төлөвлөлт
- Аялал жуулчлал зэрэг сэдвүүдээр хийнэ.

Задгай даалгаврууд нь сэдвүүдийн хүрээнд дэлхийн, бүс нутгийн, Монгол орны, аймгуудыг түвшинд газарзүйн зураг унших, зураглал хийх, шинжлэн судлах, газарзүйн мэдээллийг боловсруулах, анализ хийх, тайлбар, дүгнэлт гаргах, диаграмм, график унших, байгуулах дүн шинжилгээ хийх, тайлбарлах, статистик материал ашиглан тооцоолол хийх, дүгнэлт гаргах чадвар шалгах ба нэг асуудалд төвлөрсөн хэлбэртэй, нийт 10 оноотой байна. Физик болон нийгмийн газарзүйн агуулгыг нэгтгэсэн асуудлуудыг байх нь тохиромжтой. Даалгаврыг хэрхэн засах тухай онооны тайлбарыг хамт явуулна. Задгай даалгавар ворд файлаар 2025 оны 12 сарын 05 хүртэл tsendsuren.ts@num.edu.mn хаягаар хүлээн авна. Задгай багц даалгавар 50.000 төгрөг, тест 4.000 төгрөгийн үнэлгээтэй. Даалгавар дэд комиссоор батлагдсан тохиолдолд тантай холбогдон төлбөр шилжүүлнэ.

Хэрэгтэй холбоосууд:

<https://econtent.edu.mn/book/> сурах бичгүүд

<https://geoolympiad.org/document-library/> - өмнөх ОУ-ын газарзүйн олимпиадын даалгаврууд

<https://geography.mn/olympiad/%d0%b0%d0%b6%d0%b8%d0%bb%d0%bb%d0%b0%d1%81%d0%b0%d0%bd-%d0%bc%d0%b0%d1%82%d0%b5%d1%80%d0%b8%d0%b0%d0%bb%d1%83%d1%83%d0%b4/>

- өмнөх хоёрын давааны даалгаврууд

Монголын газарзүйн олимпиадын хороо

